

ӨГҮҮЛЭЛ

**Монгол-Канадын харилцаа, хамтын ажиллагаа:
Өргөн хүрээтэй түншлэлээс иж бүрэн түншлэлийн зүгт**

Дэнзэнлхамын Уламбаяр

*ХИС-ийн Олон улсын харилцаа, нийгэм судлалын
сургуулийн захирал, доктор, профессор
ulambayar@humanities.mn*

Хураангуй: Энэхүү өгүүлэлд Монгол Улсын “гуравдагч хөрш”, чухаг түнш, Долоогийн бүлэг, 20-ийн бүлэг, НАТО болон АПЕК-ийн гишүүн Канад ба Монгол Улсын харилцаа, хамтын ажиллагааны тухай өгүүлнэ. Монгол, Канад нь 1973 оны 11 дүгээр сарын 30-нд дипломат харилцаа тогтоосон бөгөөд, Монгол Улс 2001 оны 12 дугаар сард Оттава хотноо, Канад улс 2008 онд Улаанбаатар хотноо ЭСЯ-аа харилцан нээсэн билээ. Канад нь 1990-ээд оны эхнээс Монгол Улсад өрнөсөн ардчилсан үйл явц, зах зээлийн эдийн засгийн өөрчлөлтийг идэвхтэй дэмжиж ирсэн юм. Хоёр талын хамтын ажиллагаа улс төр, худалдаа-эдийн засаг, хөгжлийн хамтын ажиллагаа, боловсрол, батлан хамгаалах салбарт ойр дөт хөгжиж байна.

2004 оны 10 дугаар сард Монгол, Канадын “Өргөн хүрээтэй түншлэл”-ийн эрхзүйн үндэс тавигдсан. 2013 оны 10 дугаар сард Канад улсын Амбан захирагч эрхэмсэг ноён Давид Жонстон Монголд айлчилсан нь чухал ач холбогдолтой болов. 2016 оны 9 дүгээр сард Канадын парламентын Нийтийн танхимын дарга Жоофф Реган Монголд айлчлах үеэр хоёр талын “өргөн хүртээтэй түншлэл”-ийг “иж бүрэн түншлэл”-ийн түвшинд шат ахиулах талаар санал нэгдсэн болно.

Түлхүүр үгс: дипломат харилцаа, хамтын ажиллагаа, өргөн хүрээтэй түншлэл, “гуравдагч хөрш”, хэлэлцээр, айлчилал, элчин сайдын яам, найрсаг харилцаа, тунхаглал, иж бүрэн түншлэл.



Монгол, Канадын хооронд 1973 оны 11 дүгээр сарын 30-нд дипломат харилцаа тогтоосон бөгөөд 1990-ээд оноос хоёр орны хооронд харилцаа, хамтын ажиллагаа ихээхэн өргөжиж ирсэн байна. Монгол Улс харилцааг идэвхжүүлэх үүднээс 2001 онд Канадын нийслэл Оттава хотноо

ЭСЯ-аа нээсэн нь Долоогийн бүлгийн орнуудад ЭСЯ-аа нээсэн 6 дахь тохиолдол болов. Монгол Улс ашигт малтмалын үлэмж нөөцтэй нь тодорхой болж, дэлхий нийтийн анхаарлын төвд орж байсан үед Канад улс ЭСЯ-аа 2008 онд Улаанбаатар хотноо нээв.

I. Хамтын ажиллагааны шинэ эхлэл

Монгол, Канад хоёр улсын харилцааны эрхзүйн анхны суурь баримт бичиг бол 1994 оны 6 дугаар сард Оттава хотноо гарын үсэг зурсан 15 зүйл бүхий Монгол Улсын Засгийн газар, Канад улсын Засгийн газар хоорондын Худалдаа, Арилжааны тухай Хэлэлцээр болно. Энэхүү хэлэлцээрт хоёр талын худалдааны харилцаатай холбоотой эрх зүйн өргөн хүрээтэй асуудал тусгагджээ.¹

Канад улсын Сенатын дарга Г.Молгат 1997 оны 3 дугаар сард Монгол Улсад албан ёсоор айлчилсан нь тус улсын өндөр түвшний төлөөлөгчдийн хийсэн анхны айлчлал байв.²

Канад улсын Засгийн газраас гадаад улсуудад олгодог хөгжлийн тусламжийг авах эрх бүхий орнуудын тоонд Монгол Улс орох болсныг энэхүү айлчлалын үеэр албан ёсоор мэдэгджээ. Монгол Улс ардчилал, чөлөөт зах зээлийн харилцааны шилжилтийн энэ үед Канад улс олон талт хамтын ажиллагааны шугамаар үзүүлж буй дэмжлэг тусламжаа хоёр талын шугамаар өргөжүүлэх бодит боломж

нээгдсэнд сэтгэл ханамжтай байгаагаа ноён Г.Молгат онцлон тэмдэглэж байв.

Канадын Засгийн газрын тусламж хоёр механизмаар дамжин хэрэгжихээр болжээ. *Нэгд*, ядуурлыг бууруулахад чиглэгдсэн жижиг төслүүдийг “Канад сан”-гийн шугамаар голчлон Засгийн газрын бус байгууллагуудаар дамжуулан хэрэгжүүлэх бөгөөд Бээжин дэх ЭСЯ шууд хариуцах, *хоёрт*, Монголд үйл ажиллагаа явуулж буй Канадын компаниудыг дэмжих зорилгоор шинэ техник, технологи оруулж ирэхэд нь Канадын Засгийн газар Олон улсын хөгжлийн агентлагийн (КОУХА) (CIDA-Canadian International Development Agency) хөтөлбөрийн хүрээнд туслах болсон ажээ.

Хоёр тал харилцан ашигтай эдийн засгийн хамтын ажиллагаа хөгжүүлэх бодит бололцоо, нааштай нөлөөлөх хүчин зүйл багагүй байгааг цохон тэмдэглэж байв. Юуны өмнө хоёр орны байгалийн баялаг, цаг агаар, хүн амын сийрэг суурьшилт, геополитик зэрэг ижил төстэй зүйлд анхаарлаа хандуулжээ. Энэ бүхэн нь

1 Монгол Улсын Засгийн газар, Канад Улсын Засгийн газар хоорондын Худалдаа, Арилжааны тухай Хэлэлцээр, Монгол Улс, Гэрээ, Хэлэлцүүлэгийн эмхэтгэл. 9-р боть, УБ., 2001, 292-403 дахь тал

2 Канад улсын Сенатын дарга Г.Молгатын Монгол Улсад хийсэн албан ёсны айлчилал “Гадаад харилцаа”. ГХЯ-ны мэдээллийн товхимол. 1997 №10 (16)

худалдаа-эдийн засгийн харилцааг хөгжүүлэх, эрүүл мэнд, нийгмийн болон дэд бүтцийн салбарт хамтран ажиллах, харилцан туршлага солилцох өргөн боломжийг бүрдүүлж байгааг хэлэлцээний үеэр Канад улсын Сенатын дарга Г.Молгат тэмдэглэж, тодорхой салбарт хамтран ажиллах асуудлаар санал солилцжээ. Тухайлбал, Канадын эрчим хүч, дулаан хадгалалтын технологи болон мөнх цэвдэгтэй хүйтэн нөхцөлд барилга, орон сууц барих технологи, уул уурхай, мал аж ахуй, биотехнологийн чиглэлийн хамтын ажиллагаа хөгжүүлэх боломжийг судлахаар тохиролцов.

Хоёр орны худалдааны хэмжээ харьцангуй бага хэдий ч Монгол Улсад, ялангуяа уул уурхайн салбарт үйл ажиллагаа явуулж буй Канадын компаниудын тоо нэмэгдсээр байгаа тухай Сенатын дарга Г.Молгат хэвлэл мэдээллийнхэнтэй уулзахдаа тэмдэглээд “Энэ нь Канадын техник, технологи, Монголын цаг агаарын болон бусад нөхцөлд илүү тохиромжтой байдагтай холбоотой” юм гэсэн байна.

Канадад оюутан сургах, ажиллах хүч гаргах бололцоог судлан үзэх, Монголд Канадыг, Канадад Монголыг сурталчлан таниулах, бизнесийн хүрээнд мэдээлэл солилцох, худалдааны харилцааг өргөжүүлэх үүднээс бололцоо, хэрэгцээг харилцан судлах, эрдэмтэн судлаачдын хамтын ажиллагааны эхлэл, хөрөнгө оруулалтыг хөхиүлэн дэмжих үүднээс тохиолдож байгаа аливаа бэрхшээлийг хамтын хүчээр гэтлэн давах чиглэлээр хамтран ажиллах зэрэг олон асуудлыг

хоёр улсын Засгийн газар анхааралдаа авахын чухлыг харилцан тэмдэглэсэн байна.

Монгол Улсад хандивлагч орнуудын Токиогийн уулзалтад Канад улс 1997 оныг хүртэл ажиглагчийн статустайгаар оролцож ирсэн бол Канадын Засгийн газрын тусламжийг албан ёсоор хүлээн авагч орнуудын жагсаалтад Монгол Улс орсноор тийнхүү Канад улс Монголд хандивлагч орон болов. Үүний хамт дэлхийд тэргүүлэгч хөгжилтэй, ардчилсан Их долоогийн бүлгийн гишүүн орны нэг Канад нь Монгол Улсын ардчилал, зах зээлийн харилцаанд шилжих шинэчлэлт, өөрчлөлтийн үйл явцыг анхнаас нь тууштай дэмжиж буйгаа Засгийн газрынхаа бодлогын хэмжээнд Сенатын дарга Г.Молгатын айлчлал ийнхүү бодит байдлаар нотлон харуулав.

Монгол Улсын Гадаад харилцааны сайд Ш.Алтангэрэл Канадын Гадаад хэргийн сайд Л.Аксуорсид захидал илгээж, 1998 оны 11 дүгээр сарын 30-нд болох Монгол-Канадын хооронд дипломат харилцаа тогтоосны 25 жилийн ойтой холбогдуулан хоёр орны харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэх чиглэлээр тодорхой санал дэвшүүлж, харилцааны үндсэн зарчмыг тусгасан баримт бичиг боловсруулж, дээд түвшний айлчлалын үеэр гарын үсэг зурах, эдийн засгийн хамтын ажиллагааг хөхиүлэн дэмжих, бие биеийн ашиг сонирхол, боломжийг нарийвчлан тогтоох, хувийн секторын хамтын ажиллагаанд тус дөхөм үзүүлэх зорилгоор хоёр талын эдийн засгийн хамтарсан комиссыг ч байгуулан

ажиллуулж болох тухай зэрэг тодорхой саналууд байв.

Тийнхүү Монгол Улсын Гадаад харилцааны сайд Ш.Алтангэрэл Канад улсаас Монгол Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт элчин сайд Х.Баллок нар 1998 оны 2 дугаар сарын 10-нд *“Монгол Улсын Засгийн газар, Канад улсын Засгийн газрын хооронд Монгол-Канадын хамтын ажиллагааг хөгжүүлэх тухай Солилцох захидал”*-д Улаанбаатар хотноо гарын үсэг зурав.³ Гадаад харилцааны сайд Ш.Алтангэрэл элчин сайд ноён Х.Баллокийг хүлээн авч уулзах үеэр элчин сайд “...өнгөрсөн 3 жилийн хугацаанд Канадын Засгийн газар төсвийн алдагдлаа нөхөх зорилгоор тусламжийн асуудалд маш нарийн хандаж байсан ч Монгол Улс энэ хугацаанд КОУХА-гийн хөтөлбөрт хамрагдсан цорын ганц орон болов. КОУХА-гийн хөтөлбөрөөр хэрэгжих тусламжийг бид хоёр хэлбэрээр олгох бөгөөд эхнийх нь “Канадын сан”-гаар хэрэгжих бөгөөд Монголд жижиг төслүүдийг хэрэгжүүлнэ. Хоёр дахь хэлбэр нь бид Монголд хөрөнгө оруулах Канадын пүүс, компани, байгууллагуудад санхүүгийн тусламж үзүүлэх замаар хэрэгжинэ. Энэ хэлбэрийн үйл ажиллагаа цаашид өргөжинө гэж бодож байна” хэмээн онцолжээ.

Монгол Улсын Засгийн газар, Канад улсын Засгийн газар хооронд Монгол-Канадын хамтын ажиллагааг хөгжүүлэх тухай солилцох захидалд тэмдэглэсэнээр:

- Монгол Улсын Засгийн газар, Гадаад харилцааны яамаар уламжлуулан,
- Канад улсын Засгийн газар, Канадын олон улсын хөгжлийн агентлагаар уламжлуулан,
- Монгол-Канадын хооронд хөгжлийн хамтын ажиллагааны хөтөлбөрийг “Канад сан”-гийн хүрээнд хоёр талын жижиг төслүүдийг хэрэгжүүлнэ. Энэхүү сангийн зорилго нь :

Монголын тусламж шаардлагатай хүмүүст зориулагдсан жижиг бөгөөд богино хугацаанд хэрэгжин үр ашгаа өгөх санхүүжүүлэхэд оршино. Энэхүү төслийн тусламж хүлээн авагч нь байгууллага, хувь хүн, орон нутгийн засаг захиргаа, эсхүл төрийн бус байгууллага болон Монгол Улсад үйл ажиллагаа явуулж буй хүлээн зөвшөөрөгдсөн олон байгууллагууд байж болно.

КОУХА-аас хэрэгжүүлэх төслүүд нь Монгол Улсын Засгийн газар хүлээн авахуйц байх боловч Канадын сан тухайн төслүүдийг хэрэгжүүлэхэд Монгол Улсын Засгийн газраас урьдчилан зөвшөөрөл авах шаардлагагүй хэмээн ойлголцсон байна.

Канадын сан нь Бээжинд суугаа Канадын ЭСЯ-ны удирдлагын дор үйл ажиллагаа явуулах бөгөөд санхүүгийн хуваарилалт жил бүр хийгдэ, Монголын Засгийн газар зохицуулах болон тайлагнах үүрэг хүлээхгүй ажээ.

Хоёр дахь хэлбэр нь Монголд үйл ажиллагаа явуулж буй Канадын талын

3 “Монгол Улсын Засгийн газар, Канад улсын Засгийн газрын хооронд Монгол-Канадын хамтын ажиллагааг хөгжүүлэх тухай Солилцох захидал”-Монгол Улс, Гэрээ, Хэлэлцүүлэгийн эмхэтгэл. 9-р боть, УБ., 2001, 404-406 дахь тал

түнш, төрийн бус байгууллагууд болон хувийн хэвшлийн пүүс компаниудын хүсэлтийг үндэслэн КОУХА-гийн Түншлэлийг хөгжүүлэх газраас тэдэнд дэмжлэг үзүүлэхэд орших ажээ. Энэхүү хөтөлбөрийн дагуу КОУХА нь Монголд төсөл хэрэгжүүлж буй болон КОУХА-аас санхүүгийн дэмжлэг хүссэн Канадын түншүүдийн хүсэлтийг шаардлага хангасан тохиолдолд авч үздэг.

Бүх тохиолдолд төслийг санаачлагч нь төсөл хэрэгжүүлэхэд шаардагдах бүх хэлэлцээрийн хэлэлцээг Канадын Засгийн газрыг тухайн хэлэлцээрт хэлэлцэгч тал болгон татан оруулалгүйгээр явуулна. Төслийн санхүүжилт нь Канадын пүүс компаниудад Монголын Засгийн газрын зуучлалгүйгээр шууд олгогдоно⁴ гэжээ.

Канадын Гадаад хэрэг, олон улсын худалдааны департаментын Ази, Номхон далай орнуудын асуудал хариуцсан Төрийн нарийн бичгийн дарга Реймонд Чан 1998 оны 5 дугаар сард Монгол Улсад албан ёсны айлчлал хийжээ.⁵

Төрийн нарийн бичгийн дарга Р.Чан УИХ-ын дарга, Ерөнхий сайд

нарт бараалхаж, ХААҮ-ийн сайд, УИХ-ын гишүүн, Монгол, Канадын парламентын бүлгийн дарга, Ашигт малтмалын хэрэг эрхлэх газрын дарга, Гадаадын хөрөнгө оруулалтын газрын дарга нартай уулзаж, ГХЯ-ны удирдлагатай хэлэлцээ хийжээ. Тэрбээр “Канад сан”-гийн Улаанбаатар хотод явуулж буй үйл ажиллагаатай танилцжээ. Үүнд: Биокмбинатын хэсгийн эмнэлгийн байрны зориулалттай баригдсан сүрлэн байшинг үзэж, Хүүхдийн эрхийг хамгаалах төв, Зайсан дахь хүүхдийн хорих газартай хамтран хүүхдүүдэд ерөнхий боловсрол бүрэн олгох төслийг хамтран явуулж буй төсөл, Амгалан дүүрэгт *World Vision* олон улсын ТББ-ын зохион явуулж буй сульдаагийн эсрэг тэмцэх хөтөлбөртэй танилцаж, гадаад хэлний дээд сургуулийн Англи, Франц хэлний танхимын оюутнуудтай уулзалт хийжээ. Мөн хүүхдийн “Цох” сэтгүүлээс зохион явуулж буй “Канад орныг хэн сайн мэдэх вэ?” сэдэвт зохион бичгийн уралдаант байрны шагналыг гардуулах арга хэмжээнд оролцжээ.

4 Мөн тэнд

5 Канадын Гадаад хэрэг, олон улсын худалдааны департаментын Ази, Номхон далай орнуудын асуудал хариуцсан Төрийн нарийн бичгийн дарга Реймонд Чаны айлчлал- “Гадаад харилцаа”. ГХЯ-ны мэдээллийн товхимол. 1998 №10 (38)

II. “Найрсаг харилцаа, хамтын ажиллагааны тухай Тунхаглал”

Монгол Улсын Гадаад харилцааны сайдын үүрэг гүйцэтгэгч Р.Амаржаргал 1998 оны 9 дүгээр сард Канад улсад албан ёсны айлчлал хийсэн нь хоёр орны харилцааны хөгжилд чухал үе шат болов.

Ази, Номхон далайн бүс нутгийн интеграцид гүйцэтгэж буй үүрэг нь улам бүр идэвхжиж, Монголд оруулсан хөрөнгө оруулалтаараа тэргүүлж байгаа орнуудын нэг Канадтай хоёр болон олон талт улс төр, эдийн засгийн хамтын ажиллагааны цар хүрээг өргөжүүлэх боломжийг эрэлхийлэхэд айлчлалын зорилго оршиж байв. Айлчлалын гол ач холбогдол нь Монгол, Канадын харилцааны үндсэн зарчмыг тодорхойлсон Тунхаглалд гарын үсэг зурсан явдал юм.⁶ Айлчлалын үеэр Р.Амаржаргал Канадын Ерөнхий сайдын орлогч Х.Грэй, Гадаад хэргийн сайд Л.Аксуорси, Сенатын дарга Г.Молгат, Гадаад харилцааны Ази, Номхон далайн асуудал хариуцсан Төрийн нарийн бичгийн дарга Р.Чан, КОУХА-ийн Ерөнхийлөгч Х.Лабелле нартай уулзаж хоёр талын харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлэх асуудлаар дэлгэрэнгүй санал солилцжээ. Айлчлалын явцад Р.Амаржаргал Канадын бизнесийн хүрээнийхэн, Монголд хөрөнгө оруулсан компанийн төлөөлөгчидтэй хэд хэдэн удаа уулзаж, тэдний санал бодлыг сонсохын зэрэгцээ цаашид хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, хамтын ажиллагааг өргөжүүлэхэд хоёр талын Засгийн

газар дэмжин туслах, эрхзүйн үндсийг боловсронгуй болгох, КОУХА-ийн дэмжлэгийн өргөн ашиглах зэрэг тодорхой асуудлаар ярилцжээ.

Хоёр талын хамтын ажиллагааг бүс нутгийн хүрээнд идэвхжүүлэх зорилгоор Р.Амаржаргал эрдэмтэн судлаачидтай уулзаж ярилцахын зэрэгцээ Монгол Улсын гадаад бодлогын асуудлаар тусгайлан үг хэлсэн юм.

Монгол Улс ардчилал, зах зээлийн эдийн засгийн харилцаанд шилжих үйл явцыг Канад улс тууштай дэмжихээ илэрхийлж, улс төр, эдийн засгийн тусламжаа үргэлжлүүлэхийн зэрэгцээ Канадын эдийн засгийн байдал, ялангуяа төсвийн байдал сайжрахын хэрээр КОУХА-ийн тусламжийг нэмэгдүүлнэ гэдгээ илэрхийлжээ.

Канадын Гадаад хэргийн сайд Л.Аксуорсийг Монголд айлчлахыг урьж, айлчлалын үеэр *Давхар татвараас харилцан чөлөөлөх болон хөрөнгө оруулалтын хэлэлцээрт* гарын үсэг зурах тухай Монголын саналыг Канадын тал үндсэндээ нааштай хүлээн авсан байна.

Хөгжиж байгаа орнуудын өрийг хүчингүй болгох асуудлаар идэвхтэй үйл ажиллагаа явуулдгийн хувьд энэ чиглэлээр цаашид Монголыг анхааран, хамтран ажиллахаа Канадын тал илэрхийлсэн байна.

Хоёр орны гадаад харилцааны байгууллагуудын хооронд хамтын ажиллагаа хөгжүүлэх тухайлбал, Монголын ажилтнуудыг тодорхой

6 Монгол, Канадын “Найрсаг Харилцаа, Хамтын Ажиллагааны тухай Тунхаглал”-Монгол Улс, Гэрээ, Хэлэлцээрийн эмхэтгэл. 9-р боть, УБ., 2001, 406-408 дахь тал

хугацаагаар Канадад сургах асуудлыг зарчмын хувьд бололцоотой гэж үзжээ.

Хоёр талын харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлэх таатай нөхцөлийг бүрдүүлэх талаарх бололцоотой арга хэмжээг авах, тухайлбал, дипломат болон албан паспорттай иргэд харилцан визгүй зорчих зэрэг асуудлыг судалж үзэхээр тохиролцсон байна.

Р.Амаржаргалын айлчлалын үеэр *“Найрсаг Харилцаа, Хамтын Ажиллагааны тухай Тунхаглал”*-д Оттава хотноо гарын үсэг зурав.⁷ “Энэхүү Тунхаглалын зорилго нь хоёр улсын хоорондын харилцааг өргөжүүлэн гүнзгийрүүлэхэд оршино” гэжээ. Тунхаглалд цааш нь тэмдэглэхдээ: Хоёр Засгийн газрын хоорондын харилцаа нь бие биеэ харилцан хүндэтгэх, эрх тэгш байх болон олон улсын эрхзүйн нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчим, хэм хэмжээнд тулгуурлан харилцаагаа хөгжүүлэх, худалдаа, хөрөнгө оруулалтын салбарт харилцан ашигтай хамтын ажиллагааг дэмжин тус дөхөм үзүүлж, тэргүүлэх ач холбогдол бүхий ашигт малтмал, ХАА-н салбарт хамтран ажиллах бололцоог илрүүлэх, орон нутгийн хэрэгцээг хангах зорилготой богино хугацаанд хэрэгжих төслүүдийн сан болон үйлдвэржүүлэлтийн хамтын ажиллагаа явуулахад чиглэгдсэн Канадын бизнесийн санаачилга хийгээд Монгол Улсад үйл ажиллагаа явуулж

буй Канадын Засгийн газрын бус болон бусад байгууллагуудын хүсэлтийг нь үндэслэн дэмжих санг тус тус үүсгэн бий болгох тухай хөгжлийн хамтын ажиллагааны хөтөлбөрийг хамтран тохиролцов.⁸

Канад улсын Гадаад хэрэг, Олон улсын худалдааны департаментын Ази, Номхон далайн асуудал эрхэлсэн Төрийн нарийн бичгийн дарга Рей Пагтахан 2001 оны 4 дүгээр сард Монгол Улсад айлчилсан юм.⁹

Монголын тал айлчлалын үеэр Канадын Гадаад хэргийн сайдыг Монгол Улсад айлчлуулах, хүний аюулгүй байдлын хүрээнд хамтарч ажиллах, Канадын хөгжлийн тусламжийг нэмэгдүүлэх, тусламжийг “Засгийн газраас Засгийн газарт” хэлбэрээр хэрэгжүүлэх, энэ үүднээс КОУХА болон Олон улсын хөгжлийн судалгааны төвийн ерөнхийлөгч нарыг Монголд айлчлуулж ярилцах хүсэлтэй байгаагаа тэмдэглэсэн байна. Канадын Засгийн газар Ази, Номхон далайн орнуудтай харилцаагаа хөгжүүлэхийг ач холбогдолтойд үздэгээ илэрхийлээд энэ хүрээнд Монголтой хамтран ажиллах сонирхолтой буйгаа илэрхийлж, мөн Монгол оронд тохиолдсон байгалийн гамшгийг гэтлэн давахад зориулж, Канадын Засгийн газраас 110 мянган ам долларын тусламж, хоёр талын шугамаар 2001-2002 оны санхүүгийн жилд өмнөх жилийн 200 мянган канад долларын тусламжаа нэмэгдүүлж 300 мянган

7 Мөн тэнд

8 Мөн тэнд

9 Канад улсын Гадаад хэрэг, Олон улсын худалдааны департаментын Ази, Номхон далайн асуудал эрхэлсэн Төрийн нарийн бичгийн дарга Рей Пагтаханы айлчлал-“*Гадаад харилцаа*”. ГХЯ-ны товхимол. 2001 №5 (100)

канад доллар болгосноо мэдэгдэв. Айлчлалын үеэр боловсролын чиглэлийн хоёр төслийн нээлтийг хийсэн юм. Дээр дурдсан хоёр байгууллагын төлөөлөгчдийг Монгол Улсад айлчлуулах талаар анхаарч ажиллахаа Төрийн нарийн бичгийн дарга илэрхийлэв.

Хүний аюулгүй байдлын асуудлаар Монгол Улс Засгийн газрын хэмжээнд хөтөлбөр гарган ажиллаж байгаага мэдээлээд, Канад улс нь энэ чиглэлийн санал санаачилгад идэвхтэй оролцдогийн хувьд хоёр талын болон олон улсын хүрээнд хамтран ажиллахыг хүсэж, Монголын тал хүний аюулгүй байдлын хөтөлбөрөө гардуулж, Канадын тал хамтран ажиллах асуудлыг судалж үзэхээ мэдэгдсэн юм.

Монгол Улс НҮБ-ын энхийг сахиулах хүчинд оролцох бэлтгэлээ хангаж байгаа талаар мэдээлээд энэ чиглэлд Канадтай хамтран ажиллаж, тэдний зүгээс зохиож буй сургалтад ялангуяа цэргийн туслалцааны сургалтын хөтөлбөрт цаашид

хамрагдаж туршлагаас нь хуваалцах санал тавив.

Канадын тал өмнө нь Монголоос цөөн тооны хүнийг энхийг сахиулах хүчний чиглэлээр сургалтад хамруулж байснаа дурдаад, үүнийг цаашид үргэлжлүүлэх бодолтой байгаага мэдэгдсэн юм.

Канадын тал Монголоос сургах оюутны тоог нэмэгдүүлэх асуудлыг судалж үзэхээ мэдэгдсэн байна.

Хоёр орны хооронд худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааг идэвхжүүлэх боломжийг хайх зорилгоор уул уурхай, зам тээвэр, мэдээлэл холбоо, ХАА, байгаль орчны салбарын бизнесийн төлөөлөгчид төрийн нарийн бичгийн даргыг дагалдан иржээ. Тэд Монгол орны дэд бүтэц, ХАА, өмч хувьчлал, хөрөнгө оруулалтын өнөөгийн нөхцөл байдал, цаашид энэ чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар холбогдох яам, газрууд болон Монголын 30 гаруй компанийн төлөөлөгчидтэй хамтарч, бизнесийн уулзалт хийсэн юм.

III. Өргөн хүрээтэй түншлэлийн харилцааны эрхзүйн үндэс тавигдсан нь

Монгол Улсын Ерөнхийлөгч Н.Багабандийн 2004 оны 10 дугаар сарын 19-21-нд Канад улсад хийсэн төрийн айлчлал хоёр орны харилцаанд түншлэлийн шинэ хуудсыг нээв. Айлчлалын үеэр Монгол Улсын Ерөнхийлөгч Н.Багабанди болон Канад Улсын Ерөнхий сайд П.Мартин нарын Хамтарсан Мэдэгдэлд хоёр орны харилцааг цаашид **“Өргөн хүрээтэй түншлэл”**-д хүргэх, ардчилал, зах

зээлийн эдийн засгийн зарчмуудын хүрээнд өргөжүүлэх талаар хамтран хүчин чармайлт гаргахаа нотлов. **“Өргөн хүрээтэй түншлэл”**-ийн харилцааг хөгжүүлэхээр хоёр тал тохиролцсон нь Монгол Улсын “гуравдагч хөрш”-ийн бодлогыг хүрээг өргөжүүлэхэд нэн чухал ач холбогдолтой үйл явдал байв.¹⁰ Үүний дагуу хамтын ажиллагааны салбараа өргөтгөх, хэмжээ далайцыг

¹⁰ Монгол, Канадын Өргөн хүрээтэй түншлэл. УБ., 2004.10.20

нь нэмэгдүүлэхэд голлон анхаарч ажиллахад оршиж байв.

Хоёр орны хооронд улс төр, эдийн засаг, соёл боловсрол, батлан хамгаалахын чиглэлээр харилцаа өргөжсөөр байгаа юм. **Өргөн хүрээтэй түншлэлийн харилцааг хөгжүүлнэ гэдэг нь** зөвхөн уул уурхай төдийгүй, худалдаа, хөрөнгө оруулалт, ХАА, зам тээвэр, мэдээлэл, харилцаа холбоо, аялал жуулчлал, соёл боловсрол, шинжлэх ухаан, технологи, хүмүүнлэг, батлан хамгаалах, аюулгүй байдал, түүний дотор хүнсний аюулгүй байдал, байгаль орчныг хамгаалах, бүс нутгийн болон олон улсын байгууллагуудын хүрээнд хамтын ажиллагаагаа хөгжүүлэх тухай асуудал юм.

2006 оны хавар Торонто хотноо болсон олон улсын уул уурхайн чуулга уулзалтын үеэр “Монголын уул уурхайн салбарын боломж” сэдвээр холбогдох байгууллагуудтай хамтарч дугуй ширээний уулзалт зохион байгуулсан нь чухал ач холбогдолтой арга хэмжээ болов. Монгол Улс Дэлхийн уул уурхай, эрдэс баялаг, металл болон тогтвортой хөгжлийн асуудлаарх Засгийн газар хоорондын форумын гишүүн болжээ. Оттава хотод Хойд Америк-Монголын бизнесийн зөвлөлийн хурлыг уг зөвлөлтэй хамтран амжилттай зохион байгуулсан

байна.

Их Монгол Улс байгуулагдсаны 800 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх талаар НҮБ-ын тогтоол гарахад Канад улс хамтран зохиогчоор оролцсон билээ. 800 жилийн ойн хүрээнд хүндэт зочноор Канадын Парламентын Нийтийн танхимын спикер Монголд айлчлан ирж, энэ айлчлал хоёр орны улс төрийн харилцааг урагшлуулах, өндөр хэмжээний төлөөлөгчдийн харилцан айлчлах давтамжийг хадгалах, парламент хоорондын хамтын ажиллагааг өргөжүүлэхэд шинэ алхам болж байгаагаараа нэн ач холбогдолтой байв.

УИХ-ын даргын урилгаар Канадын Сенатын спикер Дэниэл П.Хэйз 2003 онд Монгол Улсад албан ёсоор айлчилж, Нью-Йорк хотноо 2002 онд Дэлхийн эдийн засгийн форумын үеэр Ерөнхий сайд Н.Энхбаяр Канадын Ерөнхий сайд Жан Кретьентэй танилцах уулзалт хийж, харилцаагаа идэвхжүүлэх арга замын талаар санал солилцсон нь хоёр орны харилцааны түүхэнд Ерөнхий сайд нарын түвшний анхны уулзалт болсон байна.

Эдүгээ Канад, Монголын дугуй ширээний уулзалтыг хоёр талын яриа хэлэлцээний гол механизм болгон тогтмол зохион байгуулж байгаа юм.

VI. Худалдаа-эдийн засгийн харилцаа, хамтын ажиллагаа

1994 онд хоёр улсын Засгийн газар хоорондын худалдааны хэлэлцээрт гарын үсэг зурснаар тус хоёр орны худалдаа, эдийн засгийн харилцааны эхлэл тавигдсан билээ. Монгол Улс 2003 оны 7 дугаар сарын 24-нд

Канадын Хөнгөлөлтийн Ерөнхий Системд (GSP) хамрагдсанаар Монгол Улсын экспортын 13 нэр төрлийн бараа, бүтээгдэхүүн 8-10 хувийн хөнгөлөлт эдлэх болсон байна. Үүнд: алт, савхин эдлэл, хивс, мах, хүнсний

Монгол, Канадын гадаад худалдааны эргэлт

Хүснэгт.1 (мян.ам.доллар)

	1997	1998	2000	2006	2017	2019
Экспорт	44.6	172.3	793.1	146.861.5	2.3	1,443.5
Импорт	1.011.3	427.4	913.2	9.711.3	29.8	46,672.3
Эргэлт	1.055.9	599.7	1.706.3	156.572.8	32.1	48,115.8

Эх сурвалж: Статистикийн Бюллетень. УБ., 2007. №2, 2019. №1

<http://ottawa.embassy.mn/eng/index1.php?moduls=24>

дайвар бүтээгдэхүүн, мал, амьтны гаралтай бүтээгдэхүүн, арьс ширэн түүхий эд, мал амьтны самнасан үс, хялгас, самнасан ноолуур зэрэг орж байна. 2017 оны эцсийн байдлаар Канад руу 2.3 сая ам.долларын бүтээгдэхүүн экспортолж, Канадаас нийт 29.8 сая ам.доллар импорт хийсэн. 2011 онд энэ үзүүлэлт 219 сая ам.долларт хүрч байжээ.¹¹ Хоёр орны худалдааны эргэлт сүүлийн жилүүдэд буурсан нь дэлхийн зах зээл дээрх ашигт малтмалын үнийн уналт, санхүү, эдийн засгийн ерөнхий нөхцөл байдалтай холбоотой байв. Монгол Улс Канадаас ХАА, уул уурхайн машин техник, өргөх буулгах төхөөрөмж, тэдгээрийн сэлбэг, харилцаа холбооны хэрэгсэл авч байна.

Канад нь Монголд оруулж буй шууд хөрөнгийнхөө хэмжээгээр БНХАУ-ын дараа 2 дугаарт орж, 1996 оноос хойших хугацаанд Канадаас Монгол Улсад нийт 300 орчим сая ам. долларын хөрөнгө шууд оруулсан нь бараг бүхэлдээ уул уурхайн салбарт ногдов. Эдүгээ Монголд Канадын 60 гаруй компани үйл ажиллагаагаа явуулж байна.

1997 онд Бумбатын алтны үндсэн орд газрыг Монгол-Канадын хамтарсан “Бумбат компани” ашиглаж эхэлсэн ба Канадын тал *Mongolia gold resoures* компани байгуулж Ванкуверын хөрөнгийн бирж болон Монголын Монгол алт корпорацад бүртгүүлсэн бөгөөд хоёр талын оролцооны хувьд 49:51 ба тус компанийн тооцоогоор эндээс жилд 1.6 тонн алт олборлохоор тохиролцож, хамтын ажиллагаа нэлээд нааштай үр дүнд хүрсэн юм.

Тосонгийн голдирлын шороон ордод “Монголын Зөвлөхүүд ХХК”, Канадын *Golden Tiger* компанитай хамтран нэмэлт хайгуулын ажил хийж орчин үеийн технологи бүхий томоохон үйлдвэрийг барьж байгуулах бэлтгэлийг хангаад 2007 оноос сайх үйлдвэрийг байгуулах ажлыг төлөвлөж, эдүгээ үйл ажиллагаа нь хэвийн үргэлжилж байгаа ажээ. Энэчлэн Канадын пүүс, компаниуд уран, газрын тос, коксождог нүүрс болон бусад эрдэс ихээхэн сонирхож байна.

2002 оны 5 дугаар сард хоёр тал **“Орлого ба хөрөнгийн татварыг давхардуулж үл ногдуулах, татвар**

¹¹ Монгол, Канадын харилцааны лавлах. ГХЯ

төлөхөөс зайлсхийх явдлаас урьдчилан сэргийлэх тухай конвенц” байгуулсан бөгөөд Хөрөнгө оруулалтыг хөхүүлэн дэмжих, харилцан хамгаалах тухай хэлэлцээр байгуулахаар тохиролцов. Канад улстай барилга, хот байгуулалт, түлш эрчим хүч, тээвэр холбоо, эрүүл мэнд, байгаль орчин, аялал жуулчлалын чиглэлээр хамтын ажиллагаа хөгжүүлэх эхлэл тавигдав.

Монгол, Канадын хөгжлийн хамтын ажиллагааны тухай баримт бичгийг 1998 онд байгуулснаар Канадын Засгийн газрын тусламжийн хөтөлбөрт Монгол Улс албан ёсоор хамрагдсан билээ. Канадаас Монголд үзүүлсэн тусламж ихэвчлэн Канадын олон улсын хамтын ажиллагааны “Канад сан”, Түншлэлийн болон олон талт хамтын ажиллагааны хөтөлбөрүүдийн шугамаар олгогдож, зарим жилд хүмүүнлэгийн болон хүнсний тусламж үзүүлж байгааг дээр тэмдэглэсэн билээ. Тусламжийн хөрөнгийн дийлэнх хэсэг нь ядуурлыг бууруулах, эрүүл мэнд, боловсрол, нийгэм дэх эмэгтэйчүүдийн оролцоог дээшлүүлэх, байгаль орчныг хамгаалах зэрэг жижиг төслүүдийг хэрэгжүүлэхэд зориулагдсан байна. Канад улс Монголд 1998-2004 онд нийт 25 сая канад долларын албан ёсны тусламж үзүүлжээ.

2013 оны 10 дугаар сарын байдлаар 1990 оноос хойш Монгол Улсад Канадын дагнасан болон хамтарсан хөрөнгө оруулалттай нийт 136 компани үйл ажиллагаа явуулж, Монгол Улсад орсон хөрөнгө оруулалтын 3.53 хувь буюу 498.05 сая ам.долларын

шууд хөрөнгө оруулалт хийсэн нь Монгол Улсад хөрөнгө оруулсан гаднын орнуудаас 6 дугаарт бичигдэж байжээ. Канадын хөрөнгө оруулалтыг салбараар нь авч үзвэл геологи, уул уурхайн эрэл хайгуул, олборлолтын салбарт 89.15 хувь, банк, санхүүгийн салбарт 1.76 хувь, худалдаа, нийтийн хоолны салбарт 8.2 хувийн хөрөнгө оруулалт тус тус ногдож байв.

1990-2017 хооронд Канад улс Монгол Улсад нийт 6,4 тэрбум ам.долларын хөрөнгө оруулалт хийжээ. 2018-2019 онд Монголд 1.9 тэрбум ам.долларын хөрөнгө оруулжээ.¹²

“Канад сан” Монгол Улсад үйл ажиллагаа явуулж эхэлснээс хойш 20 жилийн хугацаанд 21 аймгийн 240 гаруй суманд 447 төсөл хөтөлбөрт 6 сая 600 мянга орчим канад долларын буцалтгүй тусламж үзүүлсэн хэмээн Канад улсаас Монгол Улсад суугаа элчин сайд ноён Эйд Жейгэр 2017 оны 2 дугаар сард Central Tower-т болсон ойн арга хэмжээний үеэр онцолж байсан юм. Арга хэмжээний үеэр 2016-2017 онд Улаанбаатар, Дорнод, Дундговь, Өвөрхангай, Хэнтий аймагт хэрэгжих 11 төсөлд нийт 183 мянган канад долларын санхүүжилтийг олгох бөгөөд энэ удаагийн төсөлд Хавдар Судлалын үндэсний төвд эмчлүүлж буй өвчтөнүүдэд зориулсан номын сан байгуулах, нийгмийн эмзэг бүлэг болох Улаанчулуут дахь хогийн цэг орчимд амьдардаг эмэгтэйчүүдийг ажлын байртай болгох зорилготой оёдлын цех байгуулах, СХД-ийн гэр хорооллын айл өрхөд дулаан баригч бүтээгдэхүүн хандивлах, агаарын

12 Canada invested \$1.9 bl. In Mongolia. Sept. 23, 2020 <https://montsame.mn/mn/read/237405>

бохирдол, ядуурлыг бууруулах, охид эмэгтэйчүүдийг чадавхжуулах зэрэг хүний эрхийг дээдлэх, нийгмийн хөгжлийг хангахад чиглэсэн төслүүд багтсан байна. “Канад сан”-гийн үйл ажиллагааны хүрээнд Орон нутгийн санаачилга хөтөлбөр Монгол Улсад 1997 оноос хойш тасралтгүй хэрэгжиж байгаа бөгөөд Канадын ЭСЯ яам, “Канад сан”-гаас уг хөтөлбөрийг сонирхсон иргэний нийгэм, төрийн бус байгууллагуудад орон нутгийн хөтөлбөрт хэрхэн хамрах, төсөл яаж бичих талаар тогтмол зөвлөгөө өгдөг. Энэхүү сан нь хөгжиж буй орны иргэдийн эдийн засаг, соёл, нийгмийн амьдралыг дээшлүүлэхэд чиглэсэн техник, эдийн засаг, боловсрол, соёл урлаг болон нийгмийн хөгжлийг дэмжсэн

төслүүдэд жил бүр тэтгэлэг олгодог. Хөтөлбөрийн шалгаруулалт 6-9 сарын хугацаанд зохион байгуулагдаж, дөрвөн сараас нэг жилийн хугацаанд буюу богино хугацаанд хэрэгжих төслийг сонгон шалгаруулдаг байна. Канад улсын Засгийн газраас энэхүү төслийг дэлхийн хөгжиж буй 100 гаруй улсад хэрэгжүүлдэг. 1918 оны байдлаар Монгол Улсад хэрэгжиж буй төслүүдэд 260 гаруй мянган хүүхэд, 66 мянган эмэгтэй, 26 мянга гаруй өрх айл, 3300 гаруй залуус хамрагдсан байна.

Канад улсын хөгжлийн хөтөлбөрийн шугамаар 2016-2023 онд Монголд 40 орчим сая канад долларын санхүүжилт бүхий 6 төсөл хэрэгжиж байна.¹⁴

V. Иж бүрэн түншлэл өөд

Зүүн хойд Азийн бүс нутгийг өргөн утгаар нь авч үзвэл АНУ-ын адил Канад улс ч уг бүсэд багтан орох нь тодорхой билээ.¹⁵ “G7”, “G20”, АПЕК, АРФ, USMCA, НАТО, OECD-ын гишүүн **Канад улс** нь Монгол Улсын «гуравдагч хөрш», чухаг түнш бөгөөд Монгол Улсын Гадаад харилцааны сайд Ц.Гомбосүрэн анх удаа 1994 онд айлчилж байсан юм.

Монгол Улсын Ерөнхий сайд С.Батболдын 2010 оны 9 дүгээр сард Канадад хийсэн айлчлал нь хоёр орны харилцааны эрч хүч, өргөн хүрээтэй түншлэлийн хамтын ажиллагааны ач холбогдол өсөн нэмэгдэж буйг

илэрхийлсэн үйл явдал болов. Монголын тал хоёр талын харилцан үүрэг хариуцлага улам бүр нэмэгдэж буйд сэтгэл ханамжтай байгаагаа илэрхийлж, Канад улс нь Монгол Улсын хөгжлийн загвар орон болох ач холбогдолтойг тэмдэглэсэн бол Канадын тал хөгжлийн загварыг сонирхож, ардчиллын үнэт зүйлс, түүний тогтолцоо болон хоёр талын хамтын ажиллагааг бэхжүүлэхийн төлөө байгааг сайшаажээ.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн урилгаар Канад Улсын Амбан захирагч Эрхэмсэг ноён Дэвид Жонстон 2013 оны 10 дугаар сард Монгол Улсад

13 Монгол Улс дахь Канадын ЭСЯ-ны Мэдээлэл. 2017.02.15

14 Canada invested \$1.9 bl. In Mongolia. Sept. 23, 2020 <https://montsame.mn/mn/read/237405>

15 Д.Уламбаяр. Монгол Улс, Өрнө дахин: Харилцаа, хамтын ажиллагаа. XX зууны эхнээс XXI зууны эхэн. УБ.: 2010, 341-362 дахь тал

төрийн айлчлал хийв.¹⁶ Амбан захирагчийн уг айлчлал нь Канад Улсаас Монгол Улсад хийж буй анхны Төрийн айлчлал төдийгүй хоёр орны хооронд дипломат харилцаа тогтоосны 40 жилийн ойн жилд хэрэгжиж буйгаар онцлог байсан юм.

Айлчлалын үеэр Монгол Улсын Ерөнхийлөгч, Канад Улсын Амбан захирагч нар албан ёсны хэлэлцээ хийж, Монгол Улс, Канад Улс хоорондын харилцааны өнөөгийн түвшин, хэтийн төлөв, хөрөнгө оруулалтыг дэмжих, батлан хамгаалах салбарын харилцааг улам бэхжүүлэх, иргэд хоорондын харилцааг хөхиүлэн дэмжих, боловсролын салбарын хамтын ажиллагааг идэвхжүүлэх зэрэг асуудлаар санал солилцож, байр сууриа илэрхийлжээ. Ерөнхийлөгч, Амбан захирагч нар өнгөрсөн 40 жилийн хугацаанд Монгол Улс, Канад Улс нийтлэг үнэт зүйлсэд тулгуурласан бат бөх харилцааг бий болгосныг дурдахын сацуу энэхүү итгэмжилсэн харилцаа, хамтын ажиллагааг цаашид олон салбарт, түүний дотор төрийн албаны шинэчлэл, хөдөөгийн хөгжил, боловсрол, эрүүл мэнд, барилгын салбарт өргөжүүлэн хөгжүүлэх бүрэн нөөц бололцоо буйг тэмдэглэж, эдгээр чиглэлүүдэд идэвхтэй хамтын ажиллагааг өрнүүлэхээ нотлов. Амбан захирагч Дэвид Жонстон Канад Улсад суралцаж буй монгол оюутны тоог нэмэгдүүлэх, боловсролын хамтын ажиллагааг дэмжин ажиллахаа мэдэгджээ.

Албан ёсны хэлэлцээний дараа Монгол Улсын Үйлдвэр, хөдөө аж

ахуйн яам, Канадын Засгийн газрын Арилжааны корпорац хооронд хөдөөгийн хөгжлийг дэмжих чиглэлээр хамтран ажиллах санамж бичиг, Монгол Улсын Хөдөө аж ахуйн их сургууль, Канад Улсын Саскачеваны их сургууль хооронд харилцан ойлголцлын санамж бичигт тус тус гарын үсэг зурав. Мөн Монгол Улсын Засгийн газраас Монголд зорчих Канад Улсын иргэдэд 30 хоног хүртэлх хугацаанд визгүй зорчих эрх олгосон тухай шийдвэрийг Канадын талд гардуулсан байна. 2013 оны 6 дугаар сард Канад Улсын Засгийн газраас тус улсад зорчих Монгол Улсын энгийн паспорттой иргэдэд 10 жилийн олон удаагийн виз олгохоор шийдвэрлэсэн юм. Энэ нь иргэд хоорондын харилцаа, улмаар найрсаг харилцаа, хамтын ажиллагааг гүнзгийрүүлэхэд чухал алхам болж буйг хоёр тал санал нэгтгэйгээр дүгнэжээ.

Айлчлалын хүрээнд УИХ-ын дарга З.Энхболд Амбан захирагчид бараалхаж, хоёр улсын парламентын харилцааны талаар санал солилцсон бөгөөд УИХ-ын хүндэтгэлийн хуралдаанд Канад Улсын Амбан захирагч үг хэлсэн юм. Канад Улсын Амбан захирагч Эрхэмсэг ноён Дэвид Жонстонд Ерөнхий сайд Н.Алтанхуяг бараалхаж, Монгол, Канадын харилцаа, түүний дотор хөдөөгийн хөгжлийг дэмжих, “Шинэ сум” хөтөлбөрийг хамтран хэрэгжүүлэх, уул уурхайн салбарын хамтын ажиллагааг өргөжүүлэх, мөн эрүүл мэндийн салбарт хамтран ажиллах зэрэг асуудлыг хөндөж ярилцжээ.

16 <https://www.canada.ca/en/news/archive/2013/10/itinerary-state-visit-mongolia.html>

Айлчлалын хөтөлбөрийн дагуу УИХ-ын эмэгтэй гишүүд Амбан захирагч Дэвид Жонстонтой уулзаж, эмэгтэйчүүдэд тулгамдаж буй асуудлыг хэрхэн шийдвэрлэх асуудлаар ярилцсан байна.

Амбан захирагч Дэвид Жонстон айлчлалын үеэр Монгол Улс, Канад Улс нь ардчиллын нийтлэг үнэт зүйлсэд тулгуурласан итгэмжилсэн харилцааг өнгөрсөн хугацаанд хөгжүүлж чадсаныг тэмдэглэсний сацуу цаашид ч энэхүү итгэмжилсэн харилцааг хамтын ажиллагааны шинэ агуулгаар баяжуулах, иргэд хоорондын хэлхээ холбоог дэмжихэд онцгойлон анхаарахаа илэрхийлж байв. Мөн тэрбээр боловсролын салбарын хамтын ажиллагааг эрчимжүүлэхэд тусгайлан анхаарал хандуулж, одоогоор Канад Улсад суралцаж буй 265 Монгол оюутны тоог ойрын ирээдүйд дор хаяж арав дахин нэмэгдүүлэхийн төлөө ажиллахаа илэрхийлсэн юм.

Монгол, Канадын хооронд дипломат харилцаа тогтоосны 40 жилийн ойн босгон дээр Амбан захирагч Дэвид Жонстон Монгол Улсад төрийн айлчлал хийсэн нь хоёр орны харилцаа, хамтын ажиллагаанд онцгой үйл явдал болов.

2014 оны 7 дугаар сард Канад Улсын Гадаад хэргийн сайд Жон Бэйрд Монгол Улсад албан ёсны айлчлал хийсэн нь Канадын Гадаад хэргийн сайдын Монголд хийж буй анхны айлчлал болсон юм. Хоёр тал ажил хэрэгч хэлэлцээ хийж, өнгөрсөн 40 жилийн хугацаанд хоёр улсын хооронд тогтсон ойр дотно, өргөжин тэлж

буй “Өргөн хүрээтэй түншлэл”-ийн харилцааг дахин нотлов. Ардчилал, хүний эрх, хууль дээдлэх ёс зэрэг нийтлэг үнэт зүйлст тулгуурлаж, бүс нутаг, олон улсын аюулгүй байдлын тулгамдсан асуудлаар ижил төстэй байр суурийг агуулсан тогтвортой, эрчимтэй харилцаа, хамтын ажиллагааг Монгол Улс, Канад Улс хөгжүүлэхээр зорьж ирснийг сайд нар цохон тэмдэглээд, энхтайван, аюулгүй байдал, сайн засаглалыг бэхжүүлэхийн төлөө үргэлжлүүлэн хамтран ажиллаж, өнөөгийн харилцааг *“иж бүрэн түншлэл”*-ийн түвшинд өргөжүүлэхээр харилцан ярилцсан нь энэхүү айлчлалын онцлог болов.¹⁷

Хэлэлцээний чухал сэдэв нь Монгол Улс Канад улсын Засгийн газраас хөгжлийн албан ёсны тусламж үзүүлэх орнуудын жагсаалтад дахин багтсан тухай байв. Тодруулбал, тус улсын Засгийн газар нь хөгжиж буй орнуудад дэмжлэг үзүүлэх зорилгоор таван жил тутам 20-25 улсыг сонгон, хөгжлийн тусламж үзүүлдэг байна. Улмаар Канад улсын Засгийн газраас 2014-2019 онд хөгжлийн тусламж үзүүлэн, хамтран ажиллахаар сонгосон 25 орныг 2014 оны 7 дугаар сарын эхээр албан ёсоор зарласан бөгөөд тус жагсаалтад Монгол Улс сонгогджээ. Жагсаалтад багтсан орнуудад Канадын Засгийн газар жил бүр баталдаг гадаад оронд үзүүлэх хөгжлийн тусламжийнхаа дийлэнхийг зориулдаг байна. 2013 онд тус улсаас гадаад оронд үзүүлсэн нийт тусламж болох 5.2 тэрбум канад долларын 80 гаруй хувийг өмнөх жагсаалтын

17 Канад Улсын Гадаад хэргийн сайд Жон Бэйрдийн Монгол Улсад хийсэн албан ёсны айлчлал. ГХЯ-ны мэдээ. 2014.07.23-25-ны өдөр.

20 орон авч байжээ. Харин энэ удаагийн шинэ жагсаалтад багтсан 25 орон Канад улсын Засгийн газраас ирэх 5 жилд гадаад оронд үзүүлэх хөгжлийн нийт тусламжийн 90 орчим хувийг авахаар байжээ. 2014 онд багталсан 25 улсын жагсаалтад Ази тивээс дараах улсууд багтжээ. Үүнд: Афганистан, Бангладеш, Индонез (шинээр нэмэгдсэн), Монгол Улс (шинээр нэмэгдсэн), Мьянмар (шинээр нэмэгдсэн), Филиппин (шинээр нэмэгдсэн), Вьетнам оржээ.

2016 оны 9 дүгээр сард Канад улсын Парламентын Нийтийн танхимын дарга Жофф Реган (Geoff Regan) УИХ-ын дарга М.Энхболдын урилгаар Монгол Улсад айлчилжээ.¹⁸ УИХ-ын дарга М.Энхболд энэ үеэр хоёр орны харилцаа, хамтын ажиллагаа бүхий л төвшинд өргөжин хөгжиж байгаад сэтгэл хангалуун байдгаа илэрхийлж, Монгол Улс, **Канад улсын харилцааг цаашид Иж бүрэн түншлэлийн төвшинд хүргэх сонирхолтой байгаагаа нотолсон байна. Нийтийн танхимын дарга Жофф Реган Канад Улс, Монгол Улсын харилцааг цаашид Иж бүрэн түншлэлийн түвшинд хүргэх саналыг Канад Улсын Засгийн газар болон холбогдох байгууллагуудад уламжлахдаа таатай байна гэжээ.** Эрхэм зочин тэрбээр хэлэхдээ: “Канад, Монгол хоёр бол маш хүчирхэг хөрш орнуудтай. Эдийн засаг нь дэлхийн зах зээл дэх ашигт малтмалын үнийн хэлбэлзэлд өртсөн, хөгжиж буй ардчилалтай зэрэг олон талаараа адил

төстэй. Миний хувьд Монгол Улсын ардчиллын хөгжлийг дэмжих нь чухал ач холбогдолтой хэмээн үздэг бөгөөд энэ дэмжлэг нь хоёр улсын харилцаа, хамтын ажиллагааг бататгана гэдэгт итгэлтэй байна” гэжээ.

Айлчлалын үеэр талууд “*Хөгжлийн туслалцааны тухай Монгол Улсын Засгийн газар, Канад улсын Засгийн газар хоорондын Харилцан ойлголцлын санамж бичиг*”-ийг байгуулав. Санамж бичиг байгуулснаар Канадын Засгийн газраас 2017 оноос Монгол Улсад хэрэгжүүлж эхлээд буй 55,4 сая канад долларын өртөг бүхий хөгжлийн хамтын ажиллагааны төслүүдийн хэрэгжилтийн эрхзүйн үндэс тавигдаж буйгаараа чухал ач холбогдолтой болжээ.

Гадаад харилцааны сайд Ц.Мөнх-Оргил Жофф Реганд бараалхаж, харилцаа, хамтын ажиллагаагаа улам өргөжүүлэх байр суурьтай санал нэг байгаагаа тэмдэглэсэн байна. Энэ үеэр Гадаад харилцааны сайд Ц.Мөнх-Оргил, Канад Улсаас Монгол Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт элчин сайд Эйд Жейгэр нар “*Хөрөнгө оруулалтыг хөхиүлэн дэмжих, харилцан хамгаалах тухай Монгол Улсын Засгийн газар, Канад Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр*”-т гарын үсэг зурсан юм. Дурдсан хэлэлцээр нь Монгол Улсад Канадын хөрөнгө оруулалтыг татаж, улмаар Монголын иргэдэд хүртээмжтэй, эдийн засгийн хөгжил, цэцэглэлд хувь нэмэр оруулах эрхзүйн чухал бичиг баримт бичиг болж байгаа юм.¹⁹

18 Канад улсын Парламентын Нийтийн танхимын дарга Жофф Реганы айлчлал. УИХ-ын мэдээ. 2016.09.08

19 Canadian Speaker visiting <https://www.montsame.mn/en/read/11121>

Канадын Парламентын Нийтийн танхимын даргын айлчлал нь хоёр орны хууль тогтоох байгууллага хоорондын харилцааг шинэ шатанд гарахад чухал ач холбогдолтой үйл явдал болсон хэмээн талууд үзсэн юм.

Цаашлаад “Хөрөнгө оруулалтыг хөхиүлэн дэмжих, харилцан хамгаалах тухай Монгол Улс, Канад Улс хоорондын хэлэлцээр” хүчин төгөлдөр үйлчилж эхэлснийг Канадын Торонто хотноо болсон Уул уурхайн олон улсын чуулганы үеэр албан ёсоор зарлав.²⁰ Хэлэлцээрийг УИХ 2016 оны 11 дүгээр сард батламжилсан бөгөөд Канад Улсын Парламент 2017 оны 2 дугаар сард соёрхон баталжээ.

Хэлэлцээрийг дэлхийн уул уурхайн салбарын олон улсын томоохон чуулган Торонто хотноо болж байгаа үеэр ёслол төгөлдөр зарласан нь Монгол Улс гадаадын хөрөнгө оруулалтыг татах эрхзүйн орчноо тогтворжуулж, хөрөнгө оруулагчдын итгэлийг сэргээхэд чухал ач холбогдолтой үйл явдал болсон юм.

ГХЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга Д.Даваасүрэн 2019 оны 1 дүгээр

сард Канад Улсад ажлын айлчлал хийж, Канадын Гадаад хэргийн Ази-Номхон далайн асуудал эрхэлсэн туслах дэд сайд Доналд Бобиаштай (Donald Bobiash) уулзаж хоёр орны харилцаа, хамтын ажиллагааны төлөв байдал, цаашдын зорилтын талаар мэдээлэл солилцож, Монгол, Канадын уламжлалт найрсаг харилцаа, “Өргөн хүрээтэй түншлэл”-ийг улам бүр өргөжүүлэх, Канадад Монгол Улсын Худалдааны Төлөөлөгчийн газрыг байгуулах асуудлаар ярилцсан байна.²¹

2019 оны 6 дугаар сард зохион байгуулагдсан Зүүн хойд Азийн аюулгүй байдлын асуудлаарх Улаанбаатарын яриа хэлэлцээнд Канад улс Гадаад хэргийн дэд сайдын түвшинд анх удаа оролцов.

Ийнхүү Долоо болон 20-ийн бүлгийн гишүүн, Монгол Улсын “гуравдагч хөрш” Канад улстай тогтоосон “Өргөн хүрээтэй түншлэл”-ийн харилцаа шат ахиж иж бүрэн түншлэлийн түвшинд хүрэхэд ойрхон байна.

Нэгэн зүйл шүүмж

Өмнөговь аймгийн Ханбогд сумын нутагт орших ойролцоогоор 30 сая тонн зэс, 1000 тонн алтны нөөцтэй Оюутолгойн зэс, молибден, алтны ордод ордын лиценз эзэмшигч Канадын Ivanhoe Mines буюу өнөөгийн Turquoise Hill Resources компани хайгуулын ажлыг дуусган Англо-Австралийн Rio Tinto компанитай хамтран ажиллаж

байгаа билээ.

“Оюутолгой”-н газрын баялгийн 66 хувийг барьцаанд тавьж, төслийн гүнийн уурхайн санхүүжилтэд зориулж олон улсын санхүүгийн 5 байгууллага, арилжааны 15 банкнаас шаардлагатай 6 тэрбумаас нийт 4.4 тэрбум ам.долларыг зээлж, хөрөнгө босгож, үлдсэн 1.6 тэрбум ам.долларыг өөрийн хөрөнгөөр

20 https://www.canada.ca/en/global-affairs/news/2017/03/canada-ongolia_investmentagreemententersinto-force.html

21 ГХЯ-ны Мэдээ, мэдээлэл. 2019.01.25

санхүүжүүлэхээр болсноо 2015 оны 12 дугаар сард Англо-Австралийн Rio Tinto болон Канадын Turquoise Hill Resources компаниас мэдэгдэж байсан. Үүнийг гадаадын шууд хөрөнгө оруулалт гэж үзэх нь шулуухан хэлэхэд үнэхээр инээдэмтэй хэрэг болно.

Монголын тал Оюутолгойн 34 хувийг эзэмшигч боловч төслийн бүтээн байгуулалтад нэг ч төгрөг гаргаагүй. Гол нь баялгаа үнэлүүлж чадаагүй. Баялаг нь Монголынх ч хөрөнгө оруулалтын гэрээний дагуу анхны хөрөнгө оруулалтын 34 хувь нь монголчуудын эргэн төлөх зээл болоод байна. Уг эх үүсвэрийг хөрөнгө оруулагч талаас жилийн 9 хувийн хүүтэй зээлсэн бөгөөд өнөөгийн үнэ цэнээр өр төлбөр 1 тэрбум ам.долларт хүрчээ. Монголын тал 34 хувьд ногдох санхүүжилтийн зөвхөн зээлийн хүүгийн төлбөрт жилдээ 100-110 сая ам.доллар зарцуулж байгаа ажээ. Ийм байдлаар явсаар Монгол Улс 2032 онд 34 хувьд ногдох зээлийг төлж дуусах төлөвтэй байгаа юм. Монголын тал Оюутолгойн 34 хувьдаа ногдол ашиг хүртэх хугацаа улам бүр хойшилж байгаад санаагаа чилээж, сүүлдээ зарах хувилбарыг хүртэл хөндөж эхэлжээ. Ойрын жилүүдэд бондуудын өр төлбөрүүд хүлээгдэж байгаа учраас Оюутолгойн 34 хувьд ногдох өр зээлийн асуудлыг төлөх асуудал улам л хойшлох магадлалтай байна. Монгол Улс Оюутолгойн 34 хувийг эзэмшдэг нь үнэн, гэхдээ зээлээ төлж байж 34 хувийнхаа эзэн болох нь мөн л үнэн учраас хамгийн багадаа 15 жилийн дараа ногдол ашиг хүртэх эрхтэй болохоор байна. Дубайд Оюутолгойн хөрөнгө оруулагчидтай хэлэлцээ

хийсний дараагаар гүний уурхайн зардлын 4.4 тэрбум ам.долларын зээл, анхны хөрөнгө оруулалтын хэтрэлт 1 тэрбум гаруй ам.доллар, 904 сая ам.долларын татварын хөнгөлөлт зэргийг Дубайн гэрээгээр Монгол Улсын Засгийн газар хүлээн зөвшөөрснөөр бидний хүртэх ногдол ашиг анх төлөвлөсөн 2021 оноос 16 жилээр хойшилж, 2037 оны орчимд авахаар болсон бололтой. 2012-2016 оны УИХ-ын нэг ноцтой дутагдал бол “Дубайн гэрээ” гэгчид хяналт тавьж чадаагүй явдал билээ.

2009 оны 10 дугаар сард Хөрөнгө оруулалтын гэрээнд гарын үсэг зурсны дараа тухайн үеийн Ерөнхий сайд С.Баяр “Оюутолгой” төслийн өгөөжтэй холбоотой хэд хэдэн зүйл хэлж байжээ. Тухайлбал, “Уурхайн үйл ажиллагаа эхэлснээр Монголын экспортын хэмжээ 2.0-2.5 тэрбум ам. доллароор нэмэгдэж, гадаад валютын улсын нөөц арвижна”, “жилд дунджаар 580 гаруй сая ам.долларын татварын орлого улсын төсөвт орж, төслийн үргэлжлэх хугацаанд нийт татвар, орлого 29 гаруй тэрбум ам.доллароор хэмжигдэж, төсвийн орлогын найдвартай эх үүсвэр буй болж, эдийн засаг, нийгмийн олон чухал асуудлыг шийдвэрлэх таатай нөхцөл бүрдэнэ” гэж байжээ. Тэгвэл Ц.Элбэгдорж бээр сэтгүүлчдийг хүлээн авч уулзах үеэрээ “Оюунтолгой”-той байгуулсан гэрээний эхний алдагдлыг “гом охиноо хадамд алдсантай” зүйрлэж, үүнийг хүлцэн өнгөрөөж, дараагийн үе шатандаа анхаарах хэрэгтэй хэмээн хэвнэг хэлж байсан билээ.

Оюутолгойн асуудлыг УИХ-аар хэлэлцэхтэй зэрэгцэн гүнийн уурхайн

олборлолт 2023 он хүртэл хойшлогдов. Оюутолгойн зэс, алтны уул уурхайн үр шимээр Монгол Улс цэнгэлийн манлайд хүрэх ойрын ирээдүйн төлөв байдал ийнхүү үлгэр болов.

Өнөөг хүртэл төгрөгийн ханшны өөрчлөлтөд Оюутолгойн хөрөнгө оруулалт ямар ч эерэг нөлөө үзүүлж байгаагүй бөгөөд цаашдаа үзүүлэх ч үгүй болов.

Эрдэнэтийн уулын баяжуулах үйлдвэр байгуулахтай зэрэгцэн 1976 онд Зууны манлай бүтээн байгуулалт болох Эрдэнэт хотын үндэс суурийг тавьж, 10 жилийн дараа цэцэглэн хөгжсөн Монгол Улсын гуравдах том хот болтлоо хөгжиж иржээ. Гэтэл Оюутолгой төсөл хэрэгжиж эхэлснээс хойш 10 жил өнгөрчхөөд байхад хэдхэн сэндвичэн барилгаас өөр юу ч босгосонгүй. Эрчим хүчний станц ч тэр нэг адил болой.

Гэхдээ Оюутолгойн ордод хамгийн гол хөрөнгө оруулагч Англо-Австралийн Rio Tinto компанид гол үүрэг, хариуцлага ногдож байгаа бөгөөд Монгол Улсын Засгийн газар харилцан ашигтай, хамтаар хожих хамтын ажиллагааны эрхзүйн орчинг хэрхэн шинэчлэн өөрчилж, үйл ажиллагаагаа явуулж чадах эсэхээс олон зүйл хамаарч байгааг тэмдэглэх ёстой.

Санал:

Хоёр орны цаг уурын ижил төстэй байдлын нөлөөгөөр Монголын ноос, ноолууран бүтээгдэхүүн, Канадын тоног төхөөрөмж, машин механизмын худалдаа хамгийн боломжтой.

Монгол Улсын Засгийн газар, Канад Улсын Засгийн газар хоорондын

худалдаа, арилжааны тухай 1994 оны 6 дугаар сарын 8-ны өдрийн хэлэлцээр нь өнөөг хүртэл хүчин төгөлдөр хэвээр байгаа боловч тухайн үед талууд ДХБ-ын гишүүн бус байсан, худалдаа эдийн засгийн харилцаа өргөжсөн, харилцааны түвшин өөрчлөгдсөн зэргээс үүдэн цөөн нэр төрлийн барааг хамруулан Худалдааны хөнгөлөлтийн хэлэлцээр (Preferential Trade Agreement-PTA), эсвэл Чөлөөт худалдааны хэлэлцээр (FTA) байгуулах боломжийг эрэлхийлэх нь зүйтэй болов уу.

Монгол Улс, Канад Улс ДХБ-ын гишүүн орны хувьд харилцан Үндэстний нэн тааламжтай нөхцөл (Most Favored Nation-MFN), Үндэсний дэглэмийн нөхцөл (National treatment) олгодог. Монгол Улс Канадын Хөнгөлөлтийн Ерөнхий схем (GSP)-д 2003 оны 7 сарын 24-ний өдрөөс хамрагдаж байгаа боловч өнөөг хүртэл бүрэн ашиглаж чадахгүй байгаа юм. Хөнгөлөлтийн Ерөнхий Схемийг ашиглаж чадахгүй байгаа, экспортын хэмжээ, нэр төрөл нэмэгдэхгүй байгаа нь дараах хүчин зүйлсээс шалтгаалдаг. Үүнд:

1. Манай экспортын боломжтой бараа болох 6102, 6104, 6110 бүлгийн сүлжмэл хувцас Хөнгөлөлтийн Ерөнхий схемд ороогүй, Үндэсний нэн тааламжтай тариф 18 хувийн импортын татвар төлж буй. Буурай хөгжилтэй орнуудад үзүүлдэг тарифын хөнгөлөлт (LDC Tariff Rate)-өөр дээрх бүлгийн бараанууд татвараас чөлөөлөгддөг тул Монголын ноос, ноолууран бүтээгдэхүүн Бангладеш зэрэг ноос, ноолуур үйлдвэрлэдэг хөгжиж буй орнуудтай өрсөлдөх чадвар муутай байна.

2. Тарифаас гадна тарифын бус саад Монголын экспортод сөргөөр нөлөөлдөг²². Үүнд:

- Канадад жижиглэнгээр худалдаалах барааны шошго заавал Канадын албан ёсны 2 хэл болох англи, франц хэлээр хэвлэгдсэн байх ёстой. Зах зээлд нэвтрэхээр ажиллаж байгаа бол нэг жил туршилтын хугацаанд энэхүү шаардлагаас чөлөөлнө.
- Хэрвээ тамхины төрлийн бүтээгдэхүүн борлуулах тохиолдолд гадна баглаа боодлын 75 хувийг анхааруулга байх ёстой.
- Хүнсний бүтээгдэхүүний шошго, сав баглаа боодолд илүү нарийн шаардлага тавьдаг бөгөөд ДЭМБ-ын насанд хүрсэн хүний өдөрт хүнсний бүтээгдэхүүнээс авах илчлэгийн хэдэн хувийг авах талаар болон хэдэн калори агуулж буй талаар заавал мэдээлэх ерөнхий шаардлагыг тавьдаг. Хүнсний бүтээгдэхүүний сав,

баглаа боодол, бүтээгдэхүүнээс хамааран өөр өөр байдаг.

- Гоо сайхны бүтээгдэхүүний шошго арьсны төрөл болон мэдрэг чанар, харшил өгөх эрсдэлийн талаар худалдан авагчид заавал мэдэгдэх ёстой байдаг.

3. Газарзүйн байршлын алслагдмал байдлаас шалтгаалан тээвэр, логистикийн зардал өндөр байгаа зэрэг асуудлууд байгаа юм.²³

4. Монгол Улс эдүгээ дэлхийн хамгийн хурдан хөгжиж буй бүс нутагт орших болж, эрдэс баялаг, түүхий эд, эрчим хүчний үлэмж нөөцтэй нь тодорхой болсон нь олон улсын анхаарал, их гүрнүүдийн болон улс, үндэстэн дамнасан корпорациудын геополитик, геоздийн засгийн ашиг сонирхолыг эрхгүй татаж, энэ нь томоохон шинэ боломж, түүнчлэн томоохон шинэ эрсдлийг дагуулж байна. Тиймээс ч «гуравдагч хөрш»-ийн бодлогын хүрээнд үүнийг сайтар харгалзан үзэх шаардлагатай болжээ.

22 МҮХАҮТ-ын мэдээлэл. <https://www.mongolchamber.mn/> Dec. 12, 2019

23 <http://ottawa.embassy.mn/eng/index1.php?moduls=24>

Ашигласан материал:

1. Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал. УБ., 2010
2. Монгол Улсын Гадаад бодлогын үзэл баримтлал. УБ., 2011
3. Д.Уламбаяр. Монгол Улс, Өрнө дахин: Харилцаа, хамтын ажиллагаа. *XX зууны эхнээс XXI зууны эхэн*. УБ., 2010
4. C.Fred Bergsten, C. Randall Henning, Global Economic Leadership & the Group of Seven. N.Y.: 1996
5. World Bank Atlas. Washington D.C.: 2020
6. Embassy of Mongolia to Canada <http://ottawa.embassy.mn/index.php>
7. The Embassy of Canada to Mongolia <https://www.canadainternational.gc.ca/mongolia-mongolie/index.aspx?lang=eng>
8. Монгол Улсын Засгийн газар, Канад Улсын Засгийн газар хоорондын Худалдаа, Арилжааны тухай Хэлэлцээр, Монгол Улс, Гэрээ, Хэлэлцүүлэгийн эмхэтгэл. 9-р боть, УБ., 2001, 292-403 дахь тал
9. Канад Улсын Сенатын дарга Г.Молгатын Монгол Улсад хийсэн албан ёсны айлчилал-“*Гадаад харилцаа*”. ГХЯ-ны мэдээллийн товхимол. 1997 №10 (16)
10. “Монгол Улсын Засгийн газар, Канад улсын Засгийн газрын хооронд Монгол-Канадын хамтын ажиллагааг хөгжүүлэх тухай Солилцох захидал”-Монгол Улс, Гэрээ, Хэлэлцүүлэгийн эмхэтгэл. 9-р боть, УБ., 2001, 404-406 дахь тал
11. Канадын Гадаад хэрэг, олон улсын худалдааны департаментын Ази, Номхон далай орнуудын асуудал хариуцсан Төрийн нарийн бичгийн дарга Реймонд Чаны айлчлал- “*Гадаад харилцаа*”. ГХЯ-ны мэдээллийн товхимол. 1998 №10 (38)
12. Монгол, Канадын “Найрсаг Харилцаа, Хамтын Ажиллагааны тухай Тунхаглал”-Монгол Улс, Гэрээ, Хэлэлцээрийн эмхэтгэл. 9-р боть, УБ., 2001, 406-408 дахь тал
13. Канад Улсын Гадаад хэрэг, Олон улсын худалдааны департаментын Ази, Номхон далайн асуудал эрхэлсэн Төрийн нарийн бичгийн дарга Рей Пагтаханы айлчлал-“*Гадаад харилцаа*”. ГХЯ-ны товхимол. 2001 №5 (100)
14. Монгол, Канадын Өргөн хүрээтэй түншлэл. УБ., 2004.10.20
15. Монгол, Канадын харилцааны лавлах. ГХЯ

16. *Статистикийн Бюллетень*. УБ., 2007. №2, 2019. №1
17. Canada invested \$1.9 bl. In Mongolia. Sept. 23, 2020 <https://montsame.mn/mn/read/237405>
18. Монгол Улс дахь Канадын ЭСЯ-ны Мэдээлэл. 2017.02.15
19. <http://ottawa.embassy.mn/eng/index1.php?moduls=24>
20. <https://www.canada.ca/en/news/archive/2013/10/itinerary-state-visit-mongolia.html>
21. Канад Улсын Гадаад хэргийн сайд Жон Бэйрдийн Монгол Улсад хийсэн албан ёсны айлчлал. ГХЯ-ны мэдээ. 2014.07.23-25
22. Канад Улсын Парламентын Нийтийн танхимын дарга Жиофф Реганы айлчлал. УИХ-ын мэдээ. 2016.09.08
23. Canadian Speaker visiting <https://www.montsame.mn/en/read/11121>
24. <https://www.canada.ca/en/global-affairs/news/2017/03/canada-mongolia-investmentagreemententersintoforce.html>
25. ГХЯ-ны мэдээ, мэдээлэл. 2019.01.25
26. МҮХАҮТ-ын мэдээлэл. <https://www.mongolchamber.mn/> Dec. 12, 2019

Mongolia and Canada relationship: From expanded partnership towards comprehensive partnership

Ulambayar, Denzenlkham

*Dr.prof. Dean, School of International Relations and Social Studies,
University of the Humanities, Ulaanbaatar, Mongolia
E-mail; ulambayar@humanities.mn*

Abstracts: *This article discusses the relationship between Mongolia and Canada Mongolia's "third neighbor", key partner, and member of G7, G20, NATO, APEC.*

Canada recognized Mongolia in 1964 de facto and two parties established diplomatic relations on November 30, 1973 de jure.

Canada has been one of the strong supporters of the democratic processes and market economic changes that began in Mongolia in the early 1990's. Mongolia opened its Embassy to Canada in Ottawa in December 2001, and the Embassy of Canada to Mongolia was opened in Ulaanbaatar in September 2008.

The two countries are in close cooperation in political, trade and economic, developmental, education and defense spheres and particularly in mining sector.

Legal framework of Mongolia and Canada Expanded Partnership was established in October 2004. Right Honorable Mr. David Johnston, Governor General of Canada, paid a state visit to Mongolia on October 2013, which was of a significant importance.

During the visit of Geoff Regan, Speaker of the House of Commons of Canada in September 2016 in Mongolia it was agreed to step up level of bilateral relations into extended partnership towards comprehensive partnership.

Key words: *diplomatic relations, relationship, expanded partnership, "third neighbor", agreement, visit, embassy, friendly, declaration and comprehensive.*

The day of submission: 2020.10.18

Completion of review: 2020.10.29

Final decision for acceptance: 2020.10.6